**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2015 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/01 Алтай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэвэр ус төслийн ажилд хяналт тавих, барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Дарга: Д.Чинзориг -Эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч

Гишүүд: М.Батсуурь -аймгийн Ерөнхий архитектор

Ж.Мөнхцэцэг -Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Ш.Соронзонболд -Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнхдэмбэрэл -Мэргэжлийн хяналтын газрын барилгын улсын байцаагч

С.Ганзориг -Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Э.Манлай-Эрдэнэ - "Эрүүл ус" ОНӨААТҮГ-ын дарга

2. Цэвэр ус төслийн ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, тулгарч буй асуудлыг шийдвэрлэж ажиллахыг ажлын хэсэг/Д.Чинзориг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.АМГАЛАНБААТАР

C:\My Documents\2015\А-1.doc

02 02001

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 01 сарын 07 өдөр    Дугаар А/02    Алтай

## Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсан өдөрт зориулсан 2015 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдах Шатар сонирхогчдын Улсын аварга шалгаруулах тэмцээнд аймгаа төлөөлөн оролцох шатарчдад тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлж гарах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зарцуулагдах 400000 /Дөрвөн зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгөнөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Х.Баатарзориг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА    С.АМГАЛАНБААТАР

C:\My Documents\ZD ЗА-4ccc

02 01999

Аймгийн Засаг даргын 2015 оны
01 сарын 04-ны өдрийн A/02 дугаар
захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСАД ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ БАТЛАГДСАН
ӨДӨРТ ЗОРИУЛСАН ШАТРЫН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ
ШАТАРЧДЫН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Овог нэр | Регистрийн дугаар | Хүйс | Замын зардал ГАА-УБ-ГАА /мян.төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Дамдинжав Мөнхбаяр | ДС78011310 | эр | 100.0 |
| 2 | Пүрэвлхай Батбуян | ДИ48071013 | эр | 100.0 |
| 3 | Арнаа Алтанхуяг | ДЭ81041517 | эр | 100.0 |
| 4 | Сүрьеэ Энхээ | ХЗ87031108 | эм | 100.0 |
| 6 | Нийт дүн | | | 400.0 |

---oOo---

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2015 оны 01 сарын 09 өдөр Дугаар А/03 Алтай

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 46.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэн хийгдэх аймгийн Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлэгт эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх барааны түйшээгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: П.Золжаргал -Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ -Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

Гишүүд: Г.Алтангэрэл -Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

Г.Эрхэмцэцэг -Нэгдсэн эмнэлгийн лабораторийн төсвийн эрхлэгч

Д.Хажидмаа -Нэгдсэн эмнэлгийн ерөнхий нягтлан бодогч

Д.Энхжаргал -Эрүүл мэндийн газрын эмийн бодлого хариуцсан мэргэжилтэн

М.Энхтуяа- Нэгдсэн эмнэлгийн эмийн санч

2. Тендерийн баримт бичгийг боловсруулах, худалдан авах ажиллагаа зохион байгуулан, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /П.Золжаргал/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZD-3A-4.doc

02 02005

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2016 оны 01 сарын 09 өдөр          Дугаар А/04          Алтай

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ийн "а" заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 238 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 23 жилийн ойн баярын хүрээнд Үндсэн хуулийн үзэл санааг иргэд олон нийтэд түгээн таниулах, сурталчлах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн хавсралтаар батлсугай.

2. Үндсэн хуулийн 23 жилийн ойд зориулсан арга хэмжээнд шаардагдах 225000 /хоёр зуун хорин таван мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ж.Баатарзориг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА          [illegible]АМГАЛАНБААТАР

C:\My Documents\ZD-3A-1.doc

02 02007

Аймгийн Засаг даргын 2015 оны 01 сарын 09-ны өдрийн А/04 дугаар захирамжийн хавсралт

## МОНГОЛ УЛСАД АРДЧИЛСАН ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ БАТЛАГДСАНЫ 23 ЖИЛИЙН ОЙГ УГТАЖ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| № | Зардлын нэр | Тоо, ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| | Үндсэн хуулийн сэдэвт АХА тэмцээний зардал | | | |
| 1. | 1-р байр | 5 | 25000 | 125000 |
| 2 | 2-р байр | 5 | 20000 | 100000 |
| 3 | Багуудад дурсамж хийлгэх | 10 | 2000 | 20000 |
| | Нийт зардал | | | 225000 |

---оОо---

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2015 оны 01 сарын 16 өдөр          Дугаар А/05          Алтай

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ийн "і", Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3-д заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Прокурорын газрын ахмад настан О.Дуламын гэрт гэнэтийн аюул ослын улмаас учирсан хохирлыг арилгахад 150000 төгрөгийн дэмжлэг туслалцаа үзүүлсүгэй.

2. Дэмжлэг туслалцаанд олгох 150000 /нэг зуун тавин мянган/ төгрөгийг Засаг даргын батлагдсан нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Х.Баатарзориг/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА          О.АМГАЛАНБААТАР

C:\My Documents\2013A-нөөц

02 02013

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2015 оны 01 сарын 16 өдөр Дугаар А/06 Алтай

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт Засгийн газрын 151 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Алтай хотын 6 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийн өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Д.Чинзориг -Эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч

Гишүүд: А.Норов -Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч
Ж.Мөнхцэцэг -Хөгжлийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Ш.Соронзонболд -Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
Б.Лхагва-Очир -Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн
З.Мөнхнасан -Орон нутгийн өмчийн албаны мэргэжилтэн
Ц.Амарсанаа -Онцгой байдлын хэлтсийн гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч
М.Мандахжүү -Архивын тасгийн эрхлэгч
Н.Туул -Алтай хотын захирагчийн ажлын албаны мэргэжилтэн
Н.Тэгштөр -"Алтай Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ий ерөнхий инженер
Н.Батбаяр -"Алтай Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ий шугамын инженер
Ц.Үүрцайх -"Алтай Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ий дизель станцын ашиглалтын инженер
Ц.Бяруузана -"Алтай Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ий дэд станцын инженер
Б.Нямбаяр -"Электро сеть" ХХК-ий захирал

Нарийн бичиг: Ц.Ганзориг -"УБ-Электро монтаж" ХХК-ий ерөнхий инженер

2. Алтай хотын 6 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг холбогдох хууль, журмын дагуу хүлээн авахыг комиссын дарга /Д.Чинзориг/-д даалгасугай.

3. Алтай хотын 6 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийн өргөтгөл шинэчлэлтийн ажлын ашиглалт хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг "Алтай Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК /Г.Чинбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 02017

## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
## ЗАХИРАМЖ

2015 оны 01 сарын 16 өдөр  Дугаар А/07  Алтай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 7.1, 7.2 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотын нам даралтын зуухаар халаалтын үйл ажиллагаа явуулж Аж ахуйн нэгж, байгууллагын айл өрхөд үзлэг шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга: Д.Чинзориг -Эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч

Гишүүд: Ш.Соронзонболд -Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

А.Норов -Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Г.Мөнхөө -Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн аюулгүй байдлын улсын байцаагч

Ц.Амарсанаа -Аймгийн Онцгой байдлын хэлтсийн галын байцаагч

Т.Хандармаа -Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн

М.Туул -Есөнбулаг сумын Засаргчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн

Н.Сюунцэцэг -Есөнбулаг сумын Байгаль орчны улсын байцаагч

Нарийн бичиг: Б.Лхагва-Очир -Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

2. Алтай хотын нам даралтын зууханд илэрсэн зөрчил болон нам даралтын зуухаар халаалтын үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж ажиллахыг ажлын хэсэг /Д.Чинзориг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/ZAHNR-3A-4doc

02 02022

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2015 оны 01 сарын 16 өдөр Дугаар А/08 Алтай

Гадаадад томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, тайлан гаргах журмын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Япон Улсын Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулж буй Япон Улсын мужуудтай харилцаа тогтоож, хамтын ажиллагааг өргөжүүлэх зөвлөлдөх уулзалтад аймгийн Засаг дарга Очирбатын Амгаланбаатарыг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 30-ны өдрүүдэд оролцуулсугай.

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн хөтөлбөрийн дагуу шаардагдах 4881125 /Дөрвөн сая найман зуун наян нэгэн мянга нэг зуун хорин таван/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гадаад арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Х.Баатарзориг/-т зөвшөөрсүгэй.

3. Гадаадад томилолтоор ажилласан дүн, тайланг Засаг даргын зөвлөлд танилцуулж, илтгэх хуудсыг аймагт ирснээс хойш ажлын 5 хоногт багтаан Гадаад харилцааны яаманд хүргүүлэхийг Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс /Б.Мандах/-т үүрэг болгосугай.

ИРГЭН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ЭРХЭЛСЭН ОРЛОГЧ Д.БАТСАЙХАН

C:/My Documents/ZD-3A-4doc

02 02030

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2015 оны 01 сарын 16 өдөр Дугаар А/09 Алтай

Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2.2, 2.8, 2.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 85 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүүхдийн эцлан хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн, үр дүнг олон нийтэд мэдээлэн ажиллахыг Иргэн, нийгмийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч /Д.Батсайхан/, Боловсролын газар /М.Сурахбаяр/, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс /М.Эрдэнэбилэг/, сумдын Засаг дарга, сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсгийг хавсралтаар батлсугай.

3. Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санал санаачилгыг өрнүүлэн хамтарч ажиллан, ажлын үр дүн, явцыг жилийн эцэст аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсэг /Д.Батсайхан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАНБААТАР

C:\My documents\ZAHNR-3A-4doc

02 02031

Аймгийн Засаг даргын 2015 оны
01 дугаар сарын 14 ны өдрийн A/09 дугаар
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Д.Батсайхан -Иргэн, нийгмийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч

Нарийн бичгийн дарга: М.Эрдэнэбилэг -Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга

Гишүүдэд:
- Х.Мягмардаш -аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч
- С.Цагаанбаатар – Насан туршийн боловсрол төвийн захирал
- А.Амарзаяа -аймгийн ИТХ-ын ажлын албаны ахлах мэргэжилтэн
- Ж.Мөнхцэцэг -Хөгжлийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- А.Пагмадулам –Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
- М.Насанбат -Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн
- Д.Батбаясгалан -Боловсролын газрын дэд дарга
- О.Мөнхбаатар -Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй халдваргүйжүүлэлтийн хяналтын улсын байцаагч
- Д.Ариун-Эрдэнэ -аймгийн Хүүхэд эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн
- Ш.Цоодол –Олон нийтийн "Алтай радио" телевизийн редактор, МОНЦАМЭ сонины сурвалжлагч, ТВ-9 телевизийн сэтгүүлч
- П.Номин -Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн тэргүүлэгч

__oOo __

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 01 сарын 19 өдөр　　　Дугаар А/10　　　Алтай

Зарим агентлагуудыг өөрчлөн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг "Байгаль орчны газар"-ыг "Байгаль орчин, аялал жуулчлалын газар", "Боловсролын газар"-ыг "Боловсрол, соёлын газар" "Соёл, спорт аялал жуулчлалын газар-ыг" "Биеийн тамир, спортын газар", "Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар"-ыг, "Хүнс, хөдөө аж ахуйн газар" гэж тус тус өөрчилсугэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/275 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА　　　　О.АМГАЛАНБААТАР

D:/My Documents/ZD-3A-4doc

02 02036

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2015 оны 01 сарын 19 өдөр Дугаар А/11 Алтай

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд орон сууцны зориулалтаар эзэмших газрын хэмжээ, байршлыг хавсралтаар баталж 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшсэн А.Туашинтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээжүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Алтанзагас/-т даалгасугай.

3. Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Газрын тухай хууль, барилга техникийн норм, дүрмийг мөрдөж, газар эзэмших гэрээнд тусгагдсан нөхцөлүүдийг хэрэгжүүлэхийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2007 оны 08 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/ZAHNS-3A-4doc

02 02028

**ИРГЭН Авирмэд ОВОГТОЙ Түвшин ( ДЮ69011136 ) - ИЙН ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ**

Аймгийн Засаг даргын
20 ... оны ... дугаар сарын ... -ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

Нэгж талбарын дугаар: 090711146

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр болно)

Огноо: 2015-1-9

Хашааны координат

| Дугаар | X | Y | Урт | Цэгүүд |
|---|---|---|---|---|
| 1 | 5139067,068 | 288929,371 | 8,91 | 1-2 |
| 2 | 5139075,510 | 288926,534 | 8,34 | 2-3 |
| 3 | 5139078,558 | 288935,365 | 8,90 | 3-4 |
| 4 | 5139070,142 | 288938,253 | 9,40 | 4-1 |

Талбайн хэмжээ: 83,4 квадрат метр

Зураг үйлдсэн ........ М.Ариунсайнгэ
(Говь-Алтай аймгийн ГХБХБГазрын мэргэжилтэн)

(Тамга)

Хянасан ........ Д.Гандамба
(Говь-Алтай аймгийн ГХБХБГазрын дарга)